| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>7,998,900.00</b>     | <b>6,735,088.78</b>     | <b>1,263,811.22</b>   | <b>84.2</b>   |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,031,400.00            | 2,000,400.00            | 31,000.00             | 98.47         |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 5,967,500.00            | 4,734,688.78            | 1,232,811.22          | 79.34         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>58,359,900.00</b>    | <b>31,906,140.00</b>    | <b>26,453,760.00</b>  | <b>54.67</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 49,408,600.00           | 23,054,840.00           | 26,353,760.00         | 46.66         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 8,951,300.00            | 8,851,300.00            | 100,000.00            | 98.88         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>54,037,200.00</b>    | <b>75,258,156.75</b>    | <b>-21,220,956.75</b> | <b>139.27</b> |
| 2132        | Бусад урсгал шилжүүлэг   | 54,037,200.00           | 38,743,830.00           | 15,293,370.00         | 71.7          |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             | 54,037,200.00           | 38,743,830.00           | 15,293,370.00         | 71.7          |
| 2134        | Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох                    |                         | 36,514,326.75           | -36,514,326.75        |               |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг  |                         | 36,514,326.75           | -36,514,326.75        |               |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  |                         | <b>24,651,100.00</b>    | <b>-24,651,100.00</b> |               |
|             | Дотоод эх үүсвэрээр  |                         | 24,651,100.00           | -24,651,100.00        |               |
| 222001      | Тоног төхөөрөмж  |                         | 22,356,100.00           | -22,356,100.00        |               |
| 223001      | Бусад хөрөнгө  |                         | 2,295,000.00            | -2,295,000.00         |               |
| <b>1</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>1,294,733,000.00</b> | <b>1,178,276,350.00</b> | <b>116,456,650.00</b> | <b>91.01</b>  |

|            |   |                |                     |                      |        |
|------------|---|----------------|---------------------|----------------------|--------|
| 131        | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                             | 949,963,700.00 | 951,964,100.00      | -2,000,400.00        | 100.21 |
| 131001     | Улсын төсвөөс санхүүжих                             | 949,963,700.00 | 951,964,100.00      | -2,000,400.00        | 100.21 |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого                         |                |                     |                      |        |
| 132        | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                      | 253,192,900.00 | 223,389,700.00      | 29,803,200.00        | 88.23  |
| 132001     | Орон нутгийн төсвөөс                                | 253,192,900.00 | 223,389,700.00      | 29,803,200.00        | 88.23  |
| <b>133</b> | <b>ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС</b>                         |                |                     |                      |        |
| <b>134</b> | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b> |                |                     |                      |        |
| 120004     | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС               | 91,576,400.00  | 1,622,550.00        | 89,953,850.00        | 1.77   |
| 1200041    | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих           | 2,026,400.00   | 1,122,550.00        | 903,850.00           | 55.4   |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих           | 2,930,000.00   | 500,000.00          | 2,430,000.00         | 17.06  |
| 1200043    | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                       | 86,620,000.00  |                     | 86,620,000.00        |        |
| <b>122</b> | <b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>            |                | <b>1,300,000.00</b> | <b>-1,300,000.00</b> |        |
| 122        | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих                   |                | 1,300,000.00        | -1,300,000.00        |        |
| <b>124</b> | <b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>                              |                |                     |                      |        |
| 31         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл    |                | 92,030,248.23       | -92,030,248.23       |        |
| 31         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   |                | 143,059,833.47      | -143,059,833.47      |        |

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

#### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Могод сумын ЕБС нь сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Багш, удирдах ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлж, суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц гаргаж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол, "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Могод сумын ЕБС-ийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Могод сумын ЕБС-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос (106,416.8) мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл            | Эцсийн үлдэгдэл           | Өөрчлөлт                  |
|---|---------------------------|---------------------------|---------------------------|
| Б   | 1                         | 2                         | 3=2-1                     |
| Мөнгөн хөрөнгө                                    | 92,030,2                  | 143,059,8                 | 51,029,6                  |
| Авлага  | -                         | -                         | -                         |
| Байгууллагаас авах авлага                         |                           | -                         |                           |
| Бараа материал                                    | 80,962,6                  | 75,141,8                  | (5820,8)                  |
| Үндсэн хөрөнгө                                    | 1,483,363,7               | 1,331,738,2               | (151,625,5)               |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл                          | (309,397,4)               | (501,002,6)               | 191,605,2                 |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b><u>1,656,356,6</u></b> | <b><u>1,549,939,9</u></b> | <b><u>(106,416,7)</u></b> |
| Өр төлбөр   |                           | -                         | -                         |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 354,268,9                 | 354,268,9                 | -                         |
| Өр төлбөр /богино хугацаат/                       |                           |                           |                           |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b><u>1,656,356,6</u></b> | <b><u>1,549,939,9</u></b> | <b><u>(106,416,7)</u></b> |

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансанд улсын төсвийн 143,059,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ. Үүнд: дотуур байрны сурагчдын тоо төлөвлөгөөгөөр 80 хүүхэд хамруулахаас дунджаар 62,5 хүүхэд хамруулсан, үдийн цай хөтөлбөрт 225 хүүхэд

хамруулахаас хүүэд өдрийн гүйцэтгэл дунджаар 210,5 хүүхэд хамруулсан, хүнсний бүтээгдэхүүний нөөц бэлтгээгүй зэрэг нь үлдэгдэлд нөлөөлсөн байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 7.2 хувиар буюу 5,820,8 мянган төгрөгөөр буурсан нь хүнсний бүтээгдэхүүн нөөцлөөгүй, аж ахуйн материал акталж данснаас хассантай холбоотой байна. Сумын Орон нутгийн төсвөөс урсгал засварын зардалд 13,584,5 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлснийг бүртгэлд бүрэн тусгасан зарцуулсан байна. Тайлант онд 874,5 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж, БШУЯ-аас ирүүлсэн 919,1 мянган төгрөгийн сурах бичгийг дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,331,738.2 мянган төгрөг болж 461,023.0 мянган төгрөгөөр буурсан. БШУС-ын 2023 оны А/230 дугаар тушаалаар хуваарилсан сургалтын байгууллагад олгох тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын 25,731.7 мянган төгрөгөөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан цахим дэлгүүрээс 18 ширхэг 16,182,0 мянган төгрөгийн электрон таблет, 30 ширхэг 2,100,0 мянган төгрөгийн түшлэгтэй сандал зэргийг худалдан авсан байна. Принтер, свинч, 65 инчийн дэлгэц зэрэг 4 ширхэг 4 нэр төрлийн 3,134,7 төгрөгийн үндсэн хөрөнгийг нөхөн хангалтын зардлаар цахим дэлгүүрээс худалдан авах гэсэн боловч тухайн барааны нэр төрөл байхгүй зэргээс шалтгаалан ТБОНӨБАҮХАТ хуулийн хүрээнд харьцуулалтын аргаар худалдан авсан байна.

Тавилга эд хогшил дансанд 617,1 мянган төгрөг, тоног төхөөрөмж дансанд 3,449,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийж орлогод авсан бөгөөд холбогдох эрх зүйн зөвшөөрлийг Булган аймгийн Орон нутгийн өмчийн газраас авсан байна. Хандиваар 1,550,0 мянган төгрөгийн дэлгэц хүлээн авч тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн. БШУЯ-аас 271 ширхэг 33,817,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлснийг данс бүртгэлд тусгасан. Тайлант онд номын фонд данснаас 5,608,3 мянга, тоног төхөөрөмж данснаас 3421,0 мянга, тавилга эд хогшил данснаас 3,752,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, 11,322,7 мянган төгрөгийн дахин үнэлгээ хийгдсэн зэрэг нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурах шалтгаан болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,549,939.8 мянган төгрөг болж 95079,8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 597,309.8 мянган төгрөгөөр буюу 32.8 хувиар буурахад үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө буурсан нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 261,887.6 мянган төгрөгөөр өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 118,714.5 мянган төгрөг, хоол, хүнсний зардал 2,526.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

### **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,124,153.7 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 951,964.1 мянган төгрөгөөр баталж, 172.189.6 мянган төгрөгөөр бууруулсан

байна. Тайлант онд дээрх төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж, оны эцэст 951,964.1, мянган төгрөгөөр тодотгон баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 951954,1 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 223,389.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 1,175,353.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 143,059.8 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,027,337.5 мянган төгрөг буюу 87.5 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 66,302.1 мянган төгрөг, цалин 84,794.0 мянга, нормативт зардал /хоол/ 25,151,5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Хөтөлбөр                               | д/д         | Арга хэмжээ                                  | Төлөвлөгөө | Гүйцэтгэл          | зөрүү              | Биелэлт         |
|--|-------------|--|------------|--------------------|--------------------|-----------------|
| <b>71802<br/>Ерөнхий<br/>боловсрол</b> | 1           | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ             | 2387,0     | 2385,5             | 1,5                | 99,94           |
|  | 2           | 80312- Сургалт семинар                       | 1193,5     | 0                  | 1193,5             | 0               |
|  | 3           | 81605- Эрүүл мэндийг дэмжих                  | 2480,4     | 2000,0             | 480,4-             | 80,63           |
|  | 4           | 81801- Үдийн цай хөтөлбөр                    | 52190,8    | 38743,8            | 13446,9            | 74,23           |
|  | 5           | 81806-Дотуур байрны хүүхдийн хоол            | 81117,1    | 68354,2            | 12816,9            | 84,21           |
|  | 6           | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин        | 25734,7    | 25734,1            | 0,6                | 100.0           |
|  | 7           | 81823- Боловсролын багшийн сургалт           | 5619,9     | 5619,0             | 0                  | 100             |
|  | 8           | 81834- Боловсролын стандарт сургалт          | 641448,0   | 545424,7           | 96023,3            | 88,65           |
|  | 9           | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа        | 138137,8   | 112639,0           | 10788,2            | 91,26           |
|  | 10          | 81848-Сурах бичгийн түрээс                   | 2026,4     | 2000,4             | 3,1                | 98,47           |
|  | 12          | 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 253192,9   | 223389,7           | 29803,2            | 88,23           |
|  | 13          | 80112- Нийтлэг үйлчилгээ                     | 500,0      | 500,1              | -                  | 100.0           |
|  | <b>Нийт</b> |  |            | <b>1,175,353.8</b> | <b>1,102,595.6</b> | <b>72,758.2</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могод сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн урсгал засварын зардалд засвар хийх төсөв гаргаж байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэр гаргаагүйтэй холбоотой асуудлаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Могод сумын ЕБС нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл байхгүй гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 527,736.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,277.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 70 хувиар тооцон 3,694.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Булган аймгийн Могод сумын ЕБС-ийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын зарцуулалт, төсвийн зарцуулалттай холбоотой асуудлыг хянахаар тусгайлан авч үзсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 68.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 21,072.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |                 |            |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|------------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн             | Хувь       |
| Акт             | 1                      | 68.7            | 1        | 68,7            | 100        |
| Албан шаардлага | 1                      | 21,072.5        | 1        | 21,072.5        | 100        |
| Зөвлөмж         | -                      | 0               | -        | 0               | -          |
| <b>Нийт дүн</b> | <b>2</b>               | <b>21,141.2</b> | <b>1</b> | <b>21,141.2</b> | <b>100</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 3,575.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,775.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,800.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж, өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй.

##### 5.2 Албан шаардлага

1. Шатахууны зардлыг норматив зардлаар тооцоогүй, 1,775.0 мянган төгрөгөөр зарүүтэй тооцсон нь Зам тээврийн сайдын 2019 оны 390 тоо “Жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримтлаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлсэн.

##### 5.3 Зөвлөмж

Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус сургууль нь 2023 оны төсвийн жилд урсгал засварын зардалд орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан бөгөөд тухайн төсвийг зурцуулах өртгийн тооцоолол хийж өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй УСНББОУС-12, НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заалтыг тус тус зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Урсгал засварын зардлын төсөв гаргаж өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэр гаргуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| Алдааны товч утга | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс |            |     |              |     | Зөвлөмж |     |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|--------|------------|-----|--------------|-----|---------|-----|
|                   | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн |                          | Тоо    | Залруулсан |     | Залруулаагүй |     |         | Тоо |
|                   |            |     |                                   |     | Дүн                      |        | Тоо        | Дүн | Тоо          | Дүн |         |     |
| Дүн               | -          | -   | -                                 | -   | -                        | -      | -          | -   | -            | -   | -       | -   |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |         | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |        | Зөвлөмж |         | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|---|-------------|---------|---------------|-----|-----------------|--------|---------|---------|--------------------------------------|---------------------|---|-----|
|   | Тоо         | Дүн     | Тоо           | Дүн | Тоо             | Дүн    | Тоо     | Дүн     | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
|   |             |         |               |     |                 |        |         |         |                                      |                     |   |     |
| Урсгал засварын зардалд засвар хийх төсөв гаргаж ӨХЗөвлөлөөр хэлэлцүүлсэн шийдвэр байхгүй | 1           | 1,800.1 | -             | -   |                 |        | 1       | 1,800.1 | -                                    | -                   | -   | -   |
| Шатахууны зардлыг норматив зардлаар тооцоогүй   | 1           | 1775,0  |               |     | 1               | 1775,0 |         |         | -                                    | -                   |   |     |
| Дүн   | 2           | 3575,1  |               |     | 1               |        | 1       | 1800,1  |                                      |                     |   |     |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|--------------------|-------------|--------|
|--------------------|-------------|--------|

